



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А1656

Хэрлэн сум

**О.Баяртөгсийг ажлаас чөлөөлж,
тэтгэмж олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсэг, 80.1.2 дахь заалт, 82 дугаар зүйлийн 82.1.2 дахь заалт, “Хэнтий орон сууц” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хэнтий орон сууц” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Очирпүрэвийн Баяртөгсийг 2024 оны 12 дугаар сарын 11 өдрөөс эхлэн ажлын гүйцэтгэлийн хувьд гүйцэтгэж байгаа ажил үүрэгтээ тэнцэхгүй байгаа нь ажлын хэсгийн шалгалтаар тогтоогдсон тул ажлаас чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

дарга:

Д.Билгээ

Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд:

Ц.Бат-Эрдэнэ

Хөгжлийн бодлого төлөвлөлт,
хөрөнгө оруулалтын хэлтсийн
мэргэжилтэн

Э.Даваажав

“Хэнтий орон сууц” орон нутгийн
өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн
газрын нягтлан бодогч, бичиг хэрэг

3. О.Баяртөгсөд гурван сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг олгож холбогдох тооцоог хийж дуусгахыг “Хэнтий орон сууц” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Нягтлан бодогч (Э.Даваажав)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ

